

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ **Шинэчилсэн найруулга**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, бүрэлдэхүүн хэсэг, оролцогч талуудын чиг үүргийг тодорхойлж, хүүхэд хамгааллын бодлого, үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж

1.Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3.Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар тогтоосон хуулиудын хэм хэмжээ зөрчилдвөл хүүхдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг хэрэглэнэ.

1.3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

1.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа Монгол Улсын иргэн, түр болон байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд энэ хууль үйлчилнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд Монгол Улсын хилийн гадна байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд энэ хууль үйлчилнэ.

3.Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар 18 насанд хүрсэн хүний зөвшөөрснөөр энэ хуульд заасан зарим хүүхэд хамгааллын үйлчилгээг түүнийг 21 нас хүртэл үзүүлж болно.

1.4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.1.“хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхдийг зүй бус хандлага, дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдал, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;

1.2.“хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж хүүхдийн бие махбодь, эрүүл мэнд, сэтгэл санаа, ёс суртахуун, оюун ухааны хөгжилд сөргөөр нөлөөлөх, хор хохирол учруулах бие махбодийн шийтгэл, мөлжлөгийн аливаа хэлбэр, үл хайхрах байдал, ялгаварлан гадуурхал, зүй бус хандлага, сэтгэл санааны болон бэлгийн дарамтыг;

1.3.“хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор шуурхай туслах, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээг;

1.4.“эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин алдагдсан, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн эсхүл өртөх нөхцөл байдалд байгаа эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй эсхүл гамшиг, онцгой нөхцөл байдалд байгаа; эсхүл бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн, тэвчишгүй хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг;

1.5.“хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг шалгах үе шатанд татагдан оролцож байгаа, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, эрүүгийн хариуцлага болон зөрчлийн шийтгэл хүлээсэн, гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа хүүхдийг;

1.6.“хүүхдийн эрхийн төлөөлөл” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцож хүүхэдтэй холбоотой шийдвэр гаргах ажиллагаанд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахыг;

1.7.“Хамтарсан баг” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг;

1.8.“Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээний талаар шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий орон нутгийн нэгжийг;

1.9.“асралт гэр бүл” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг тодорхой хугацаанд асран хүмүүжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн, энэ хуульд заасан шаардлагыг хангасан гэр бүлийг;

1.10.“хүүхэд хамгааллын кейс менежмент” гэж нийгмийн ажлын үйлчилгээ шаардлагатай эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлэн шууд үзүүлэх дэмжлэг, холбон зуучлалаар дамжуулан цаг хугацаанд нь тохиромжтой хэлбэрээр, системтэй шийдвэрлэх мэргэжлийн цогц үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх арга замыг;

1.11.“мэргэжлийн удирдлага” гэж нийгмийн ажилтны арга зүйн чадамж, практикийг дэмжих, хүүхэд, түүний гэр бүлд мэргэжлийн үр өгөөжтэй үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж, нийгмийн ажилтныг удирдан чиглүүлэх, дэмжих, хөгжүүлэх зорилготой үйл ажиллагааг;

2.Энэ зүйлд зааснаас бусад хуульд заасан нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, захиргааны хэм хэмжээний акт, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг баримтална.

1.5 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын зарчим

1.Хүүхэд хамгаалалд дараах зарчмыг баримтална:

1.1.хүүхэд хамгааллын бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээнд хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих, хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах;

1.2.хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;

1.3.хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд хүүхдийг нэн тэргүүнд төрөл, садангийн болон бусад ойр дотны гэр бүлийн асрамжид байлгахыг анхаарч үзэх, хүүхдийг аль болох ах, эгч, дүүтэй нь хамт байлгах;

1.4.хүүхдийн нөхцөл байдал, онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх;

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээ авах хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол орчуулагч, хэлмэрч заавал оролцуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо

1.Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо нь хууль тогтоомж, хүүхэд хамгааллын байгууллага, мэргэшсэн хүний нөөц, төсөв, санхүү, хүүхэд хамгааллын үйлчилгээ, мэдээллийн сан, хяналт-шинжилгээ, үнэлгээ бүхий олон талт, цогц хамтын ажиллагаанаас бүрдэнэ.

2.Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгайлан заасан тохиолдолд тухайн үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно.

3.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь тухайн байгууллагынхаа хүрээнд хэрэгжүүлэх хүүхэд хамгааллын бодлогыг батлан мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.Энэ зүйлийн 3-т заасан хүүхэд хамгааллын бодлого нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын зарчимд нийцсэн, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн байна.

5.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, дэд бүтцийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх, хандив туслалцаа үзүүлэх замаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмжин оролцож болно.

6.Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нь хүүхэдтэй харьцдаг ажлын байранд тавигдах шаардлагад ажил хайгч, ажилтан хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэж байгаагүй байх шаардлагыг тусгана.

2.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалт

1.Хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалт нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнаас бүрдэнэ.

2.Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

3.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоохдоо нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо зэргийг шалгуур үзүүлэлт болгоно.

2.3 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын талаарх хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх;

1.3. хүүхэд хамгааллын салбар дундын хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;

1.4.хүүхэд хамгааллын үйлчилгээний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, батлуулах;

1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, төсвийг батлуулах, хяналт тавих;

1.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

2.4 дүгээр зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих чиг үүрэгтэй.

2.Төрийн захиргааны байгууллага нь хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх арга хэмжээг авах, мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээг үндэслэн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжилтийг хангах;

2.2.хүүхэд хамгааллын үйлчилгээний үр дүнг Засгийн газар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн өмнө хариуцан жил бүр тайлагнах;

2.3.Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг, хүүхэд харагч, өдөр өнжүүлэх төв, төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж байгаа хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

2.4.хүүхдийг гэр бүл, нийгмийн бүх орчинд эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

2.5.хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйг боловсруулах, хүүхэд хамгааллын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах;

2.6.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, нийгмийн ажилтныг чадавхжуулах сургалтын хөтөлбөр баталж хэрэгжүүлэх;

2.7.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, боловсрол, эрүүл мэндийн болон төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагчдыг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар сургаж, мэргэшүүлэхэд тухайн байгууллагатай хамтран ажиллах;

2.8.хүүхэд хамгаалалд бүх шатны төрийн байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэн, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих;

2.9.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үнэлэх, дүгнэх;

2.10.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх;

2.11.хүүхэд хамгааллын үйлчилгээний хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх;

2.12.хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв, санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

2.13.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харилцах талаар нийгмийн ажилтан, хууль сахиулах байгууллагын албан хаагчийг сургах, мэргэшүүлэх ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

2.14.хуульд заасан бусад чиг үүрэг.

3.Энэ зүйлийн 2.9-д заасан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.Энэ зүйлийн 2.10-т заасан мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.5 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын чиг үүрэг

1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.харьяа орон нутгийн түвшинд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг, сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, хүүхэд харагч, өдөр өнжүүлэх төв, төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж байгаа хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, үр дүнг үнэлэх;

1.2.эрсдэлт нөхцөл байгаа хүүхэд болон хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.3.бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

1.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, шаардлагатай тусламж, үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах;

1.5.төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллах;

1.6. гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, хамгаалах талаар шаардлагатай зөвлөгөө, сургалт, тусламж, дэмжлэг үзүүлэх;

1.7.эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлэх, бүртгэх, судалгаа авах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажлыг орон нутгийн цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.8. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;

1.9.харьяалах орон нутагт төрийн байгууллага, аж ахуйн нэгж, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын ажилтан, алба хаагчдыг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

1.10.хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээлэл, судалгаанд дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;

1.11.хуульд заасан бусад чиг үүрэг.

2.Аймаг, нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

3.Дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын даргыг нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

2.6 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан

1.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан /цаашид “нийгмийн ажилтан” гэх/ дараах үүргийг гүйцэтгэнэ:

1.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэл хүлээн авах, мэдээлийг нягтлан шалгах, бүртгэх;

1.2.шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах;

1.3.эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, эдгээрт үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээг төлөвлөх, үзүүлэх, үнэлэх, хаах, эргэн хянах;

1.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх оролцогч талуудыг удирдан чиглүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах, шилжүүлэх, үйл явц, үр дүнг үнэлж кейс менежментийн зохицуулалтыг хийх;

1.5.хүүхэд хамгааллын кейс бүрийн үйлчилгээний үйл явцыг холбогдох журам, зааврын дагуу бүртгэх, баримтжуулах, архивлах, мэдээллийн санд оруулах;

1.6.хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

1.7.хүүхдийн эрүүл мэнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн талаар, түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хүүхдийг төлөөлөн зохих байгууллагад хүсэлт, өргөдөл гаргаж шийдвэрлүүлэх;

1.8.хүүхэд хамгааллын асуудлаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад хүн, бүлэг, хуулийн этгээд, олон нийтэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, сургалт, зөвлөгөө өгөх, шаардлага тавих;

1.9. зөрчил, гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

1.10. үйл ажиллагаандаа нийгмийн ажил, үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх;

1.11. мэргэжлийн ёс зүй, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

1.12. хуульд заасан бусад үүрэг.

2.Нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүсэхээр бол цагдаагийн байгууллагын туслалцааг авах эрхтэй. Цагдаагийн байгууллага нийгмийн ажилтны хүсэлтийн дагуу түүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг даруй авах үүрэгтэй.

3.Нийгмийн ажилтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эрх, мэргэжлийн зэрэг олгох, цуцлах асуудлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

4.Нийгмийн ажилтан ёс зүйн дүрэмтэй байна. Нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийг мэргэжлийн холбоодтой зөвшилцөн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.7 дугаар зүйл. Хүүхэд хамгаалалд төрийн бус байгууллага болон олон улсын байгууллагын оролцоо

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

2.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг чадавхжуулах сургалтыг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

3.Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын мэдээллийн санг төрийн захиргааны байгууллага бүртгэж, хөтөлнө.

4.Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр нь Монгол Улсын хүүхэд хамгааллын бодлого, хүүхэд хамгааллын үйлчилгээний шаардлагад нийцсэн байна.

5.Төрийн бус байгууллага нь мэргэжлийн ёс зүйн дүрэм, нийгмийн ажил, үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах бөгөөд хэрэгжилтэд Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хяналт тавина.

6.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр тандалт, судалгаа хийхийг хориглоно.

7.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага нь хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болно.

I дэд бүлэг **Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг**

2.8 дугаар зүйл. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо

1. Аймаг, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо /цаашид “Хууль зүйн хороо” гэх/-г тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцөн байгуулна.

2. Хууль зүйн хороо нь хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын; нутгийн захиргааны байгууллагын; боловсролын; эрүүл мэндийн; цагдаагийн; шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын; прокурорын нэгжийн; шүүхийн тамгын газрын удирдах албан тушаалтнуудаас бүрдэнэ. Энэ хэсэгт заасан байгууллагууд нь харьяа Хууль зүйн хороотой хамтран ажиллаж, чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

3. Хууль зүйн хорооны гишүүд болон Ажлын алба нь тухайн хороонд хандсан, шийдвэр гаргуулсан хүүхдийн талаар мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд Хууль зүйн хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан, ажилтнаас энэ талаар баталгааг бичгээр гаргуулна.

4. Хууль зүйн хорооны Ажлын албаны үүргийг аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага гүйцэтгэнэ.

2.9 дүгээр зүйл. Хууль зүйн хорооны ажиллах чиг үүрэг

1. Хууль зүйн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1. гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хүлээн авах, шүүхээс хүүхдэд даалгасан үүргийг биелүүлэхэд зөвлөгөө өгөх, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.2. сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаад суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

1.3. гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа хүүхдийг эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны сөрөг нөлөөллөөс хөндийрүүлэх зорилгоор мөрдөн байцаах байгууллагатай хамтран ажиллах, хүүхдэд батлан даагч томилуулахаар санал гаргах;

1.4. гэмт хэрэгт холбогдсон хүүхдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авснаас бусад тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хүүхдийн сурч боловсрох эрхийг тасалдуулахгүй байх, тайлбар, мэдүүлэг авах, хүүхдийг оролцуулах шаардлагатай бусад мөрдөн шалгах ажиллагааг хүүхдийн байгаа газарт нь зохион байгуулах;

1.5.гэмт, хэрэг зөрчилд холбогдсон, эрүүгийн хариуцлага болон зөрчлийн шийтгэл хүлээсэн хүүхдийг зөв зохистой хүмүүжил олгох сургалт, хөтөлбөрт хамруулах;

1.6.эцэг, эх, гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн, сургууль, хамт олонд нь зөвлөгөө өгөх, тогтмол хугацаанд уулзалт, ярилцлага зохион байгуулж, үр дүнг тооцох;

1.7.хорт зуршлаас ангижрах эмчилгээнд хамруулах, зөвлөгөө өгөх, ажил, сургууль, мэргэжил олгох сургалтад хамруулах;

1.8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

2.Хууль зүйн хорооны гаргасан шийдвэр, үзүүлсэн тусламж үйлчилгээний мэдээллийн санг Ажлын алба бүрдүүлж, үндэсний хэмжээнд мэдээллийн сангийн үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллага удирдлагаар хангаж, хяналт тавина.

2.10 дугаар зүйл. Хууль зүйн хорооны хуралдаан, түүнээс гарах шийдвэр

1.Хууль зүйн хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас гарах шийдвэр нь тогтоол, зөвлөмж хэлбэртэй байна.

2.Хууль зүйн хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.Ажлын алба Хууль зүйн хорооны хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, холбогдох баримт бичгийг гишүүдэд тараасан байна.

4.Хууль зүйн хорооны гишүүн хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд Хууль зүйн хорооны даргад урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

5.Хууль зүйн хорооны шийдвэрийн хэрэгжилтэд Хууль зүйн хорооны гишүүд биечлэн болон Ажлын албаар дамжуулан хяналт тавина.

6.Хууль зүйн хорооны тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлээгүй эсхүл хэрэгжүүлэхэд саад учруулсан төрийн албан хаагчид ёс зүйн болон сахилгын хариуцлага тооцуулахаар томилсон эрх бүхий этгээд, албан тушаалтанд санал хүргүүлнэ.

2.11 дүгээр зүйл. Хууль зүйн хороо холбогдох талуудтай харилцах

1.Хүүхэд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч болсон байж болзошгүй талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан цагдаагийн байгууллага, албан хаагч энэ талаар тухайн харьяа Хууль зүйн хороонд

24 цагийн дотор мэдэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох боломжоор хангана.

2.Хууль зүйн хорооноос томилогдсон төлөөлөгч нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхэдтэй холбогдох мөрдөн шалгах ажиллагаанд оролцох боломжоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хангагдана. Энэ заалт нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн гэрч, хохирогч хүүхдээс шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд нэгэн адил үйлчилнэ.

3.Шүүх хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй гомдол, нэхэмжлэлийг хүлээн авагч иргэний хэрэг үүсгэснээс хойш 7 хоногийн дотор тухайн шүүхийн тамгын газраараа дамжуулан харьяа Хууль зүйн хороонд мэдэгдэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хүлээн авсан Хууль зүйн хороо хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг ашиг сонирхолтой, эсхүл шүүхээс гарах шийдвэр хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал байгаа тохиолдолд хүүхдийн эрхийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргаж, холбогдон ажилтныг томилон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулна.

5.Мөрдөн байцаах байгууллага, шүүх хүүхдийн эрх зөрчигдсөн эсэх, хүүхдийн амьдарч, сурч байгаа орчны нөхцөл байдлыг тогтоолгох зорилгоор харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, нийгмийн ажилтныг шинжээчээр томилж дүгнэлт гаргуулж болно. Энэ тохиолдолд шинжээчийн зардлыг тухайн томилсон байгууллага хариуцан төлнө.

6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн талаарх мэдээллийг хоригдлыг суллах, тухайн арга хэмжээ дуусахаас 30 хоногийн өмнө харьяа Хууль зүйн хороонд мэдэгдэнэ.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан мэдээллийг хүлээн авсан Хууль зүйн хороо чиг үүргийнхээ хүрээнд тухайн хүүхдэд шаардлагатай тусламж, дэмжлэгийг хүргэх талаар зохих шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.12 дугаар зүйл. Хамтарсан баг

1.Хамтарсан баг нь тухайн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтантай хамтран ажиллана.

2.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуульд заасны дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээний тодорхой чиглэлээр мэргэшсэн дэмжих багийг байгуулж болно.

4.Сум, хорооны нийгмийн ажилтан Хамтарсан багийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

5.Хамтарсан багийн гишүүн хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн талаарх мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд үйлчилгээ үзүүлэх явцад хамтран ажиллаж буй хувь хүн, байгууллагатай нууцын гэрээг байгуулна.

6.Хамтарсан баг нь хүүхэд, гэр бүлд үзүүлсэн үйлчилгээг нийгмийн ажилтны мэдээллийн санд бүртгэж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлд хүргүүлнэ.

7.Нийгмийн ажилтны мэдээллийн сангийн хөтлөх, ашиглах журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

2.13 дугаар зүйл. Хамтарсан багийн чиг үүрэг

1.Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээний хугацаатай төлөвлөгөөг баталж, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

1.2.хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих;

1.3.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, иргэдийн хяналтыг бий болгох;

1.4.тухайн жилд хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардлагатай төсвийн саналаа боловсруулж харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлэх.

2.14 дүгээр зүйл. Хамтарсан багийн зохион байгуулалт

1.Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд Хамтарсан багийн гишүүдийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцож, асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ.

2.Хамтарсан багийн хуралдаанаас гарах шийдвэр нь дүгнэлт, тэмдэглэл хэлбэртэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛ, НИЙГМИЙН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

3.1 дүгээр зүйл. Гэр бүл дэх хүүхэд хамгаалал

1.Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрхээ урвуулан ашиглах, мөлжлөг, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийллийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авна.

2.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, асран хамгаалахад шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн

асуудал хариуцсан орон нутийн байгууллага, холбогдох бусад байгууллагад хандаж зөвлөгөө, мэдээлэл авах эрхтэй.

3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэддээ авах эрхтэй.

4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд үл харшлахаас бусад тохиолдолд хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явцад оролцох, хамтран ажиллах, мэдээлэл авах эрхтэй.

5.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, төрөл, садан, багш сурган хүмүүжүүлэгч, гэрийн үйлчилгээний ажилтан нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

6.Эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхдээ түүнтэй зүй бус харьцах, бие махбодийн болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.

7. Хуульд зааснаас бусад тохиолдолд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь аливаа шан харамж, төлбөр авах зорилгоор хүүхдийг бусад этгээдэд өгч ажил, хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

8.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн амьдарч байгаа орчны эрсдэлийг таньж илрүүлэх, арилгах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

9.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол холбогдох хуулиар хариуцлага хүлээнэ.

3.2 дугаар зүйл. Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал

1.Боловсрол, сургалтын болон сургалтын бусад байгууллага /цаашид “сургалтын байгууллага” гэх/ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний журам, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

2.Сургалтын байгууллага хүүхдийг тухайн орчинд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршил, дээрэлхэх үйлдэл, сэтгэл зүйн болон бие махбодийн хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх;

2.2.зүй бус хандлага, дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдал, дээрэлхэлт, гэмт хэрэг, хорт зуршилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ийм үйлдэлд холбогдсон болон хохирогч хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулах;

2.3.сургалтын байгууллагын багш, ажилтанд хүүхдийн эрх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар сургалт, зөвлөгөө өгөх;

3.Сургалтын байгууллагын захиргаа, багш, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сайн дурын ажилтан хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дээрэлхэлтийн талаар мэдсэн, таамагласан, эсхүл хүүхэд тодорхойгүй шалтгаанаас 3 ба түүнээс дээш хоног

хичээлдээ ирээгүй тохиолдолд тухайн сургуулийн хүүхэд хамгааллын баг болон холбогдох хүүхэд хамгааллын байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

4.Энэ зүйлийн 3-т заасан мэдээллийн дагуу сургалтын байгууллагын удирдлага, сургуулийн хүүхэд хамгааллын баг нэн даруй хяналт, шалгалт явуулна. Хяналт, шалгалтаар хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн, дээрэлхэлт гарсан нь тогтоогдвол сургалтын байгууллага дараах арга хэмжээг авна:

4.1.хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийлэл, дээрэлхэлт нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байвал холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

4.2.хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн, дээрэлхэлтийн хохирогч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх;

4.3.хүчирхийлэл, дээрэлхэлтийн талаар мэдээлсэн сурагчийн мэдээллийн нууцыг хадгалах, цаашид хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

4.4.хохирогч хүүхдийг сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд нэн даруй хамруулах;

5.Эцэг, эх, хүүхдийн оролцооны байгууллага, сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага нь сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын бодлогод хөндлөнгийн хяналтыг тавина.

6.Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багаас үзүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санг бий болгож, мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг өөрийн төсвийн багцад тусгана.

Тайлбар: -Энэ зүйлд заасан "дээрэлхэлт" гэж нэг буюу хэд хэдэн сурагч өөр нэг буюу хэд хэдэн сурагчийг санаатайгаар, удаа дараа бие махбодь, оюун ухаан, сэтгэл санааны хувьд гэмтээх, зовоох, айлган сүрдүүлэх, заналхийлэх зорилготой түрэмгий зан үйлээ биеэр, амаар, цахим хэлбэрээр илэрхийлэхийг ойлгоно.

3.3 дугаар зүйл. Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал

1.Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагч, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй заавал мэдээлнэ.

2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд

байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна.

3.Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу үзүүлж, мэдээллийн сан хөтөлнө.

4.Эрүүл мэндийн ажилтан, албан хаагчдыг хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар сургаж чадавхжуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.Эрүүл мэндийн байгууллага, ажилтны мөрдөх хүүхэд хамгааллын бодлого, бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

3.4.Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал

1.Эцэг, эх, асран хамгаалагч гэр бүлийн орчинд, багш, сургуулийн нийгмийн ажилтан сургуулийн орчинд, хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, хуулийн этгээд бусад орчинд өөрсдийн эрх, үүргээ хэрэгжүүлэх замаар хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээлээс хамгаална.

2.Харилцаа холбооны зохицуулах хороо, цагдаагийн төв байгууллага хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөргөөр нөлөөлөх бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээлээс хүүхдийг хамгаалах талаар зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж цахим орчин, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчийн хүүхдэд зориулсан бүх төрлийн дуу авиа, дүрс, үйл явдал оруулсан контент, бүтээл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж үзсэн иргэн, хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, хүүхдийн эрхийн улсын байцаагч энэ тухай гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороонд гаргаж шийдвэрлүүлнэ.

4.Сонин хэвлэл, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, цахим орчин ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.16 насанд хүрээгүй хүүхэд бусад хүүхдийнхээ эсрэг хийсэн энэ зүйлийн 4-т заасан үйлдлээс үүсэх хохирол, хор уршгийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хуульд заасны дагуу хариуцна.

6.Үүрэн холбооны, интернетийн болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь хүүхдэд зориулсан тусгай багцын үйлчилгээтэй байх бөгөөд үйлчилгээний гэрээ байгуулахдаа тухайн этгээдийн асран хамгаалалд 18 нас хүрээгүй хүүхэд байгаа эсэхийг заавал асууж, насанд хүрэгчдэд зориулсан тусгай

сувгийн үйлчилгээ эсхүл шүүлтүүртэй интернетийн үйлчилгээг хэрэглэх эсэхийг тохиролцоно.

7.Цахим орчин болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүрээнд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах орон тооны бус дэд зөвлөл Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дэргэд ажиллана. Орон тооны бус дэд зөвлөлд иргэд, интернетийн болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөлтэйгөөр хүүхэд хамгааллын салбар дундын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавина.

8.Үүрэн холбооны болон интернетийн үйлчилгээ эрхлэгч нь цахим орчинд хүүхдийн эсрэг агуулгатай, хууль зөрчсөн контентийг өөрийн сүлжээнд даруй хязгаарлах үүрэг хүлээнэ.

9.Иргэн, албан хаагч бүр цахим орчинд хүүхдийн эрх зөрчигдсөн, дарамт хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн байж болзошгүй тохиолдлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, Хамтарсан баг болон цагдаагийн байгууллага, Хүүхдийн тусламжийн утсанд мэдээлнэ.

3.5 дүгээр зүйл. Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал

1.Худалдаа, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал цуглаан, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөл, осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд ханган ажиллана.

2.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг зохион байгуулагч хууль, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрах нөхцөл бүрдсэн, эсхүл хохирол учирсан бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

3.Энэ зүйлийн 1-д заасан арга хэмжээ, үйлчилгээний үед хүүхдийн эрх зөрчигдсөн гэж үзсэн хувь хүн, хуулийн этгээд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн тусламжийн утсанд мэдэгдэх үүрэгтэй.

4.Олон нийтийн үйлчилгээ, арга хэмжээний үед хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.

3.6 дугаар зүйл. Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал

1.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхгүй орчинд оролцуулна.

2.Хүүхдийг соёл, спортын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, спортын тэмцээн, бусад арга хэмжээнд оролцуулахдаа хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг авна.

3.Хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хоцрогдлыг арилгах арга хэмжээг эцэг, эх, асран хамгаалагч, арга хэмжээнд оролцуулсан этгээд хамтарч сургалтын хөтөлбөр, агуулгын хүрээнд авах, төрийн захиргааны байгууллагаас улс, бүс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцсон бол сургуулийн удирдлага тус тус зохион байгуулна.

4.Улсын баяр наадам, шигшмэл, бүсийн уралдаан болон бусад аливаа хэлбэрийн хурдан морины уралдааны бэлтгэл үе шат /үсэргээ, сунгаа/, уралдаанд эцэг эх, асран хамгаалагч, уяач нь уралдаанч хүүхдийн эрх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, дараах арга хэмжээг авна:

4.1.уралдаанч хүүхдийн сурч боловсрох эрхийг зөрчихгүй, хязгаарлахгүй байх;

4.2.уралдаанч хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж нас, жин, өндрийг тусгайлан тэмдэглэж дүгнэлт гаргуулах;

4.3.уралдаанч хүүхдийг стандартын шаардлага хангасан хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангаж, гэнэтийн ослын даатгалд даатгуулах;

4.4. хүүхдийн бие махбодид гэмтэл учирсан, амь нас, эрүүл мэндэд эрсдэл учрах нөхцөл байдал бий болсон үед хүүхдийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн даруй хамруулах;

4.5.уяач нь уралдаанч хүүхдийн эцэг эхтэй хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, урамшуулал, бай шагналыг тусгасан гэрээ байгуулах, энэ зүйлийн 4-т заасан хурдан морины уралдааны бэлтгэл үе шат эхлэхээс өмнө морь унах уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхдээс бичгээр зөвшөөрөл авч, нийгмийн ажилтанд бүртгүүлнэ.

5.уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, стандартын хэрэгжилтэд тухайн орон нутгийн Засаг дарга, хуулиар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага хяналт тавьж ажиллана.

6.Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлагыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

7.Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журмыг соёлын, биеийн тамир, спортын болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран баталж, мөрдүүлнэ.

3.7 дугаар зүйл. Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал

1.Хүүхэд ямар ч хориглолт хязгаарлалтын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ авах эрхтэй.

2.Цар тахал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг боломжит бүхий л хэлбэрээр хүргэх бөгөөд хуульд заасан хүүхэд хамгааллын үйлчилгээг зогсоохыг хориглоно.

3.Цар тахал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд цахим платформ, тоон гарын үсэг, зөвшөөрөл ашиглаж болох ба төрийн бүхий л байгууллага, албан тушаалтнууд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.Цар тахал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлэх үйл ажиллагааг хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, сайн дурын ажилтны оролцоотойгоор зохион байгуулна.

5.Гамшгаас хамгаалах болон гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны бүхий л шатанд баримтлах Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батлана.

-Тайлбар: Энэ зүйлд заасан “төрийн байгууллага” гэж хүүхэд хамгааллын, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, Хүний эрхийн үндэсний комиссыг ойлгоно.

3.8 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хүүхэд хамгаалал

1.Цагдаагийн алба хаагч, прокурор, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх, туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа хүүхдийн талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, нийгмийн ажилтанд заавал мэдэгдэж, тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусах хүртэл хугацаанд хамтран ажиллаж, оролцоог хангана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хүүхдийг нас сэтгэхүйн онцлогт тохирсон мэдээллээр хангаж, өөртэй нь холбоотой шийдвэр гаргах ажиллагаанд үг хэлэх, үзэл бодол, саналаа илэрхийлэх боломжоор хангана.

3.Мөрдөн байцаах байгууллага, шүүх нь хүүхдийг байлцуулан тайлбар, мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг хийхдээ тусгайлсан өрөө, хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохирсон орчин бүрдүүлэх үүрэгтэй.

4.Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар байвал хүүхдийн талаархи мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, түүний мэргэжилтэн нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хүүхдийн асрамж тогтооход Шүүхийн шинжилгээний тухай хуульд зааснаар шинжээчээр оролцож болно.

6.Энэ зүйлийн 5-д заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох мэргэжилтнийг сургах, бэлтгэх, гэрчилгээжүүлэх ажлыг

хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран зохион байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

4.1 дүгээр зүйл. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх арга хэмжээг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, нийгмийн ажилтан хүүхэд, гэр бүл, иргэд, олон нийт, хүүхэд харьцдаг этгээдээс өргөдөл, мэдээлэл хүлээн авах боломжит бүхий л аргыг ашиглан илрүүлнэ.

2. Хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах болон мэдээлэл, зөвлөгөө авах эрхтэй. Энэ талаар хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид мэдэгдэх нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй тохиолдолд мэдээллийн нууцлалыг чандлан хадгална.

3. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн эрх зүйн бүрэн чадамжтай хэн боловч энэ талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл сум, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

4. Цагдаагийн байгууллагын албан хаагч, сургалтын байгууллагын захирал, эрхлэгч, менежер, багш, нийгмийн ажилтан, түүнчлэн эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, лам, санваартан, гэрийн үйлчилгээний ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын ажилтан, нийгмийн халамжийн байгууллагын албан хаагч, нийгмийн ажил, үйлчилгээ эрхэлдэг хүмүүс ажил, албан үүргээ гүйцэтгэх явцдаа хүүхдийн зан байдал, хүмүүжил, нөхцөл байдалд хяналт тавих, хүүхэд эрсдэлт нөхцөлд орсон бол энэ талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, хүүхдийн тусламжийн утсанд мэдэгдэх онцгой үүрэгтэй.

5. Энэ зүйлийн 4-т заасны дагуу мэдээлэх үүрэг нь тухайн этгээдийн баримтлах ёс зүйн дүрэм, мэргэжлийн нууц, хууль, гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргийн зохицуулалтаас давуу үйлчилнэ.

6. Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулна.

4.2 дугаар зүйл. Мэдээлэл өгөгчийг нууцлах

1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэл өгсөн этгээд нь өөрийнхөө тухай мэдээллийг бусад этгээдэд задруулахгүй байх хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийн нууцлалыг хамгаална.

2. Энэ зүйлд заасан мэдээллийн нууцлалыг хамгаалахад мэдээлийн эх сурвалж, мэдээлэл өгөгчийн нэр, хаяг, хувийн нууцад хамаарах бусад мэдээллийг хамгаалах, бусдад задруулахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.

4.3 дугаар зүйл. Шуурхай тусламжийн үйлчилгээ

1. Энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл хүлээн авсан, эсхүл эрсдэлт нөхцөл байгаа хүүхдийг өөрөө илрүүлсэн нийгмийн ажилтан хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүссэн, эсхүл үүсч болзошгүй тохиолдолд хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлнэ.

2. Шуурхай тусламжийн үйлчилгээний хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээ, хууль зүйн туслалцаа, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээг нэн даруй үзүүлнэ.

3. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул учирсан, эсхүл учирч болзошгүй, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд 72 цагаас илүүгүй хугацаагаар түр тусгаарлах арга хэмжээг цагдаагийн алба хаагч эсвэл нийгмийн ажилтан нэн даруй авна.

4. Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

5. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

6. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл үүссэн, эсхүл үүсч болзошгүй тохиолдолд хүүхэд шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлнэ.

4.4 дүгээр зүйл. Нөхцөл байдлын үнэлгээ хийх, төлөвлөх

1. Нийгмийн ажилтан хүүхдийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж, хүүхэд хамгааллын шаардлагатайг үйлчилгээг тодорхойлох зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Нийгмийн ажилтан шаардлагатай тохиолдолд Хамтарсан багийн гишүүд эсвэл холбогдох мэргэжилтний туслалцааг авч болно.

2. Нөхцөл байдлын үнэлгээнд хүүхдийн бие махбодь, сэтгэл санаа болон гэр бүлийн нөхцөл байдал, хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах харилцаа, хүүхдийн сургуулийн орчин, нөхцөл байдал, хүүхдийн зан байдал, хүмүүжил, эрүүл мэнд зэрэг хүүхэдтэй холбоотой бүхий л нөхцөл байдлыг үнэлж, тусгана.

3. Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлт, саналыг үндэслэн хүүхэд хамгааллын кейс төлөвлөлт хийнэ. Төлөвлөгөөг тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацаанд өөрчлөлт оруулж, бусад этгээдтэй хамтарч ажиллах шаардлагатай эсэхийг тодорхойлно.

4. Хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг сайжруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээний цогц төлөвлөгөөг бичгээр гаргах бөгөөд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, 7-оос дээш насны хүүхдийн оролцоог хангаж ажиллана. Эцэг, эх, асран

хамгаалагч болон хүүхэдтэй зөвшилцөлд хүрэх боломжгүй тохиолдолд төлөвлөгөөг дангаар баталж хэрэгжүүлж болно.

5.Алслагдмал газар, засаг захиргааны нэгж эсхүл төрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй тодорхой хэсэгт хүүхэд хамгааллын үйлчилгээг явуулын хэлбэрээр хүргэх асуудлыг төлөвлөгөөнд тусгана.

6.Хүүхэд, түүний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

7.Нөхцөл байдлын үнэлгээ хийсэн нийгмийн ажилтанд нэмэгдэл урамшууллыг хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын дагуу олгоно.

4.5 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

1.Хүүхэд хамгааллын кейс хариуцах төрийн болон төрийн бус байгууллагын нийгмийн ажилтан, мэргэжилтэн энэ хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4-т заасан төлөвлөгөөний дагуу хүүхдийг гэр бүлийнх нь орчинд хамгаалах, нөхөн сэргээх дараах үйлчилгээг үзүүлнэ:

1.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийг асрах, өсгөж хүмүүжүүлэх болон нийгмийн ажлын үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.2.хүүхдийг нийгэмшүүлэх, эргэн хэвийн амьдралд ороход нь туслах зорилгоор хүүхдийн онцлог, хөгжлийн түвшинд тохируулан хөгжлийн, амьдрах ухааны сургалт, үйл ажиллагаанд хамруулах, чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөхөд тохиромжтой үйл ажиллагаанд холбон зуучлах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.3.хүүхэд, эцэг, эхийн харилцааг сайжруулах, харилцааны зөрчил, хямралыг шийдвэрлэх сургалт, дэмжих бүлгийн үйлчилгээнд хамруулах;

1.4.амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор гэр бүлд тусламж, дэмжлэг үзүүлэх, ажлын байранд холбон зуучлах,

1.5.нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, мэдээлэл өгөх;

1.6.архи, согтууруулах ундаа, мансууруулах ба сэтгэцэд нөлөөлөх эм, бодисын хамааралтай эцэг эх, асран хамгаалагчтай ажиллах тусгай хөтөлбөр гаргаж, үйлчилгээнд хамруулах;

1.7.хүчирхийллийн харилцаатай эцэг, эх, асран хамгаалагчийг зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын хөтөлбөрт хамруулах;

1.8.сургууль завсардсан хүүхдийн чадвар, сонирхлыг судалж, зохих боловсролын байгууллагад холбон зуучлах;

1.9.Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын хүрээнд хүүхдээр хөнгөн ажил эрхлүүлэх, аюултай, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх;

1.10.хүүхэд үрчилж авсан эцэг, эхэд эцэг, эхийн үүрэг, хариуцлага хүлээх, үрчлэх үйл ажиллагааг дуусгавар болгох, үрчлэлтийг цуцалсан тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах зэрэг асуудалд туслалцаа үзүүлэх.

2.Энэ зүйлд заасан гэр бүлийн орчинд нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх ажлыг нийгмийн ажилтан зохион байгуулж, үйлчилгээний явц, үр дүнд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, ажилтан байнгын хяналт тавина.

4.6 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

1.Энэ хуулийн 4.5 дугаар зүйлд заасан үйлчилгээ үр дүнд хүрээгүй эсхүл уг үйлчилгээг үзүүлэх боломжгүй тохиолдолд хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.

2.Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд дараах үйлчилгээ хамаарна:

1.1.түр хамгаалан байрлуулах үйлчилгээ;

1.2.хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ:

1.2.1.хүүхдийг төрөл, садан, ойр дотны гэр бүлд байлгах;

1.2.2.хүүхдийг асралт гэр бүлд байлгах;

1.2.3.хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1.1, 1.2-ын 1.2.1, 1.2.2-т заасан үйлчилгээг үзүүлэх эсэхийг сум, дүүргийн Засаг дарга, 1.2-ын 1.2.3-т заасан үйлчилгээг үзүүлэх эсэхийг аймаг, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

4.Аймаг, сум, дүүргийн Засаг дарга хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, өөрчлөх эсэхийг шийдвэрлэхдээ Хамтарсан баг, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын санал, дүгнэлтийг авна.

5. 7 нас хүрсэн хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэхдээ түүний саналыг авна.

6.Аймаг, сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүчингүй болгох, эсхүл өөрчилнө.

7.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журам, иргэн, хуулийн этгээдэд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам, сургалтын хөтөлбөрийг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хоол, хүнс, хувцас, зөөлөн эдлэл, эм, ариун цэвэр, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг хэмжээг санхүү, төсвийн болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хамтран батална.

4.7 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үндэслэл

1. Аймаг, сум, дүүргийн Засаг дарга дараах үндэслэлээр хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ:

1.1. эцэг, эх нь нас барсан;

1.2. эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр нас барсан, сураггүй алга болсонд тооцогдсон;

1.3. эцэг, эх нь хоёулаа шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд эсхүл хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон;

1.4. шүүхээс эцэг, эх байх эрхийг нь хязгаарласан, хассан;

1.5. эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй;

1.6. эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдийг асран халамжлах үүргээ удаа дараа биелүүлээгүй;

1.7. эцэг, эх нь хүүхдээ асран халамжлах чадваргүй болсон;

1.8. эцэг, эх нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн болон хүүхдийг үл хайхарсны улмаас хүүхдийн бие махбодь, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахууны хөгжилд эрсдэл учирсан.

2. Нийгмийн ажилтан хуульд заасан үндэслэлээр гэр бүлээсээ тусгаарлагдан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийг боломжтой тохиолдол бүрд гэр бүлд нь эргэн нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавина.

4.8 дугаар зүйл. Хүүхдийг төрөл, садан, ойр дотны болон асралт гэр бүлд байлгах

1. Хүүхдийг төрөл, садангийн болон ойр дотны бусад гэр бүлд байлгах тохиолдолд тухайн гэр бүлийн зөвшөөрлийг урьдчилан авч, тухайн гэр бүлийн нөхцөл байдалд Хамтарсан баг эсхүл хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага үнэлгээ хийнэ.

2. Хүүхдийг асралт гэр бүлд байрлуулах тохиолдолд тухайн гэр бүл нь энэ хууль болон холбогдох эрх зүйн актад заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана.

3. Асралт гэр бүлийн эхнэр, нөхөр нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.Хүүхдийг хүүхдийг төрөл, садан, ойр дотны гэр бүл болон асралт гэр бүлд байлгахдаа тухайн гэр бүлтэй сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага хүүхэд асран хамгаалах тухай гурвалсан гэрээ байгуулна.

4.9 дүгээр зүйл. Хүүхдийг асран хамгаалах тухай гэрээ

2.Хүүхэд асран хамгаалах тухай гэрээнд дараах зүйлийг тусгана:

2.1.хүүхдийг сурах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангах;
2.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асран хамгаалуулагчийн эрх, үүрэг;

2.3.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг;

2.4.асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад тэтгэмж, хөнгөлөлт,

2.6.асран хамгаалуулагчийн эд хөрөнгө;

2.7.гэрээ дуусгавар болох хугацаа, үндэслэл, бусад үр дагавар.

3.Хүүхдийг асран хамгаалахад тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл байдал бий болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь буцаан өгсөн, үрчлүүлсэн бол сум, дүүргийн Засаг дарга, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын санаачилгаа, хүндэтгэн үзэх бусад шалтгаан /өвчилсэн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ буй болсон бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно..

4.Хүүхдийг асралт гэр бүлд байлгахтай холбоотой зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн үйлчилгээний сангаас санхүүжүүлнэ.

5.Хүүхэд асран хамгаалах тухай гэрээний загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.10 дугаар зүйл. Хүүхэд асран хамгаалуулахыг хориглох

1.Дараах хүнийг хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр томилох, уг хүнтэй хүүхэд асран хамгаалах гэрээ байгуулахыг хориглоно:

1.1.насанд хүрээгүй;

1.2.эцэг, эх байх эрхээ хасуулсан, хязгаарлуулсан, эсхүл ийм арга хэмжээ авагдаж байсан;

1.3.цагдан хоригдох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан болон зорчих эрхийг хязгаарлах, хорих ял эдэлж байгаа;

1.4.хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан;

1.5.үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхэд хамгааллын үйлчилгээнээс хасагдсан, гэрээ нь цуцлагдсан асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асралт бүл;

1.6.хүүхдийг асран хүмүүжүүлэх санхүүгийн чадамжгүй;
1.7.өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;
1.8.үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн.;
1.9.өнгөний болон дархлаллын олдмол хомсдол, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй;
1.10.архи, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм,
бодисын хамааралтай.

2.Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ авсны дараа энэ зүйлд заасан үндэслэл илэрсэн, бий болсон тохиолдолд сум, дүүргийн Засаг дараг уг үйлчилгээг нэн даруй цуцална.

3.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавина.

4.11 дүгээр зүйл. Хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах

1.Хүүхдийг төрөл, садан, бусад ойр дотны болон асралт гэр бүлд байлгах боломжгүй эсхүл уг үйлчилгээнд хамруулсан ч үр дүнд хүрээгүй тохиолдолд аймаг, дүүргийн Засаг дарга хүүхдийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах эсэхийг шийдвэрлэнэ.

4.12 дугаар зүйл. Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг цуцлах үндэслэл

1.Хүүхдийг гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг дараах үндэслэлээр цуцална:

1.1.гэрээ цуцлагдсан;
1.2.гэрээний талууд харилцан тохиролцсон;
1.3.гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний хугацаа дууссан;

1.4.хүүхэд үрчлэгдсэн;
1.5.хүүхэд 18 насанд хүрсэн бөгөөд үргэлжлүүлэн 21 нас хүртэл хүүхэд хамгааллын үйлчилгээ авахыг зөвшөөрөөгүй;

1.6.энэ хуулийн 4.7 дугаар зүйлд заасан үндэслэл хүчингүй болсон;
1.7.асран хамгаалагч, харгалзан дэмжигч эсхүл асралт гэр бүлийн эхнэр, нөхөр нас барсан;

1.8.гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг өөрчилсөн;

1.9.хуульд заасан бусад үндэслэл.

4.13 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ

1.Урьдчилан сэргийлэх үйлчилгээг хүүхэд хамгааллын кейс менежмент, нотолгоонд суурилан боловсруулж, урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлнэ.

2. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь дараах төрөлтэй байна:

- 2.1. зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ;
- 2.2. олон талт, хамтарсан арга хэмжээ.

3. Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь төрийн захиргааны төв, нутгийн захиргаа, шүүх эрх мэдэл, болон хууль сахиулах, хяналт шалгалтын чиг үүрэг бүхий байгууллагаас зохион байгуулах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилтай уялдсан байна.

4. Яам, агентлаг болон төрийн бусад байгууллага эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнд оролцох, сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй.

4.14 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын кейс менежмент

1. Нийгмийн ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд, түүний гэр бүлд хэрэгцээтэй байгаа хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхойлох, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, үйлчилгээг хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх бусад байгууллага, мэргэжилтэнтэй холбох, тэдгээрийг удирдан чиглүүлэх, уялдаа холбоог хангах, хянах, үнэлэх, хүүхэд хамгааллын кейсийг хаах үе шатын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ.

2. Нийгмийн ажилтан нь хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнгийн талаар хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, Хамтарсан багийн гишүүд, оролцогч бусад талуудын санал, үнэлгээг авах, тэдэнтэй ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, зөвлөгөөн хийх, холбогдох талуудаас мэдээлэл авах зэргээр хүүхэд хамгааллын үйлчилгээний үйл явц, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

3. Нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын кейсийг хаахдаа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан тухайн орон нутгийн байгууллагатай зөвшилцөнө.

4. Хүүхэд хамгааллын кейс нь нэгдсэн бүртгэл, дугаартай байна.

5. Нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын кейсийг нээхээс хаах хүртэлх хугацаанд хүүхэд хамгааллын үйлчилгээний хүрээнд хийгдсэн бүх шийдвэр, үйл ажиллагааг холбогдох маягт, зааврын дагуу заасан хугацаанд баримтжуулж, биет болон цахим хэлбэрээр хадгалж, мэдээллийн санд оруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА

5.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлага, түүний хэлбэр

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг

дээшлүүлэх чиглэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлага нь хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн нэгдсэн зохион байгуулалтын болон хүүхэд хамгааллын тодорхой кейстэй холбоотойгоор удирдан чиглүүлэх, сургах, дэмжин туслах, холбох зэрэг хэлбэрээр хэрэгжинэ.

3. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.Нийгмийн ажил, үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

5.2 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ, судалгаа, дүгнэлтэд үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээний мэргэжлийн удирдлагын хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох, тухайн үеийн нөхцөл, шаардлагыг харгалзан доод шатны байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааг хүртээмжтэй төлөвлөж хэрэгжүүлэх;

1.2.хүүхэд хамгааллын үйлчилгээнд гарч буй алдаа дутагдал, хүндрэл, бэрхшээлийг тухай бүр тодорхойлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор нэгдсэн зөвлөмж, аргачлал, зааврыг боловсруулж, мөрдүүлэх;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний статистик мэдээ болон хүүхэд хамгааллын кейсүүдээс түүвэрлэн хянаж, нийтлэг гарч байгаа алдаа, дутагдлыг тогтоож, зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах;

1.4.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас доод шатны албан хаагч, нийгмийн ажилтан мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар дурдсан хугацаанд хэрэгжүүлсэн ажлыг шалгаж, биелэлтийг дүгнэх;

1.5.хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын албан хаагч, нийгмийн ажилтнуудтай ганцаарчилсан болон хамтарсан уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, шаардлагатай зөвлөмж, зөвлөгөө өгөх.

1.6.нийгмийн ажилтныг сургах, давтан мэргэшүүлэх, ажлын байран дээр зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх;

5.3 дугаар зүйл. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагаас мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагаа

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1. тухайн орон нутгийн Хамтарсан баг, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

1.2. хүүхэд хамгааллын кейс бүрийн материалтай танилцаж, алдаа, дутагдлыг илтгэх хуудаст тусгах, хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад хийгдэж байгаа ажиллагаа, баримтжуулалтад хяналт тавих;

1.3. тухайн орон нутгийн хэмжээнд гарч буй нийт хүүхэд хамгааллын кейсийн статистик мэдээ, кейст менежмент хийж буй байдал зэргийг үндэслэн Хамтарсан баг, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдэд зохих чиглэл тус бүрээр сургалт зохион байгуулах, ганцаарчилсан болон хамтарсан уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлуудаар ярилцлага хийх, чиглэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

1.4. Хамтарсан баг, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээдийг мэргэжлийн удирдлагаар хангах хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцох, биелэлтэнд нь хяналт тавих.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, САНХҮҮЖИЛТ

6.1 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт

1. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүр өөрийн нутаг дэвсгэр дэх хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар тухайн шатны хүүхдийн төлөө зөвлөлийн тайлан, Засаг даргын саналыг хэлэлцэж, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжүүлэх арга хэмжээг авна.

3. Олон улсын байгууллага, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага, хуулийн этгээдээр хүүхэд хамгааллын чиглэлээр хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж болно.

4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага хүүхдийн эрхийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын талаар жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд тайлагнана.

6.2 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын хяналт, шинжилгээ, үнэлгээ

1.Хүүхэд хамгааллын нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээг үнэлэх зорилгоор төрийн захиргааны байгууллага нь дараах хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

1.1.орон нутаг, анхан шатны нэгжээс эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар бүртгэл, судалгааг нэгтгэн дүгнэх;

1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийн талаар бүртгэл, судалгааг Хууль зүйн хороо, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагатай хамтран гаргаж, дүн шинжилгээ хийх;

1.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж, шалгах;

1.4.хүүхэд хамгаалалд төрийн байгууллагуудын оролцоог үнэлэх;

1.5.хүүхэд хамгааллын хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг үнэлэх;

1.6.Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг өөрөө эсхүл бусад мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

6.3 дугаар зүйл. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

1.1.улсын төсөв;

1.2.орон нутгийн төсөв;

1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний чиглэлийн үндэсний олон улсын төсөл, хөтөлбөр;

1.4.дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламж.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг энэ хуульд заасан төрөл, хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

3.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төсөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейст тулгуурлаж, дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтооно.

4.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хамтарсан баг, Хууль зүйн хороо ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

5.Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хуваарилагдсан төсвийг төрийн захиргааны байгууллага, Хууль зүйн хороо, Хамтарсан багаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг

илрүүлэх, тэдэнд хүүхэд хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсний дараа хяналт тавихтай холбогдох үйл ажиллагаанд зарцуулна.

6.Байгууллага, аж ахуйн нэгж нь жилийн төсвийнхөө нэг хувийг хүүхэд хамгааллын бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэхэд зарцуулна.

7.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

7.1. дүгээр зүйл. Гомдол гаргах

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх явцад гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн гэж үзвэл хүүхэд, хүүхдийн бүлэг, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн элч, магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага нь дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол, мэдээлэл гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй.

7.2 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

1.Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын Их Хурал, Засгийн газар, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөл, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэл дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагч, хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан тус тусын чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж, харилцан мэдээлнэ.

2.Хүүхдийн эрхийн улсын байцаагч энэ хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээллийг нийгмийн ажилтанд, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад мэдэгдэх, зөрчлийн шинжтэй үйлдлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх;

2.2.тухайн өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах явцад хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлэх;

2.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний явцад болон гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

2.4.хүүхдийн эрхийг зөрчсөн албан хаагч, ажилтанд сахилгын хариуцлага тооцох асуудлыг эрх бүхий этгээдэд тавьж шийдвэрлүүлэх;

2.5.түр хамгаалах байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллага, үйл ажиллагаа явуулж байгаа газар саадгүй нэвтрэх, холбогдох баримт бичиг, мэдээлэлтэй танилцах;

2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

7.3 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.4 дүгээрзүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 2022 оны дүгээр сарын -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг